

Global HR Forum + Сөүл, Үлсан, Бүсан туршлага судлах тусгай хөтөлбөрт аялал

Аяллын үнэд багтсан	Форумын үеийн синхрон орчуулга, бүх өдөр мэргэжлийн хөтөч болон орчуулагчтай, зочид буудал [<i>Бизнес зочид буудалд 2-оороо байрлах</i>], бүх өдрийн хоол, аяллын зориулалттай автобус, аяллын үзвэр үйлчилгээний төлбөр, дотоодын нислэг, аяллын иж бүрэн даатгал			
Аяллын үнэд багтаагүй	Хувийн хэрэглээний зардал			
Аяллын унаа	Жуулчны зориулалтын автобус + дотоодын нислэг			
Ачаа:	МИАТ-ын нислэгийн энгийн стандарт суудлын дагуу 1 ачаа 23 кг хүртэлх байдлаар зохицуулах шаардлагатай бөгөөд, дотоодын нислэгийн хувьд ачааны жингийн хязгаарлалтгүй байх хөнгөлөлтийг БНСУ-ын Төрийн өмчит Нисэхийн Корпораци зөвхөн энэ аялалд үзүүлж байна.			
Өдөр	Маршрут	Агуулга	Зочид буудал	Хоол
11-р сарын 4 (Мягмар)	УБ - Инчон - Сөүл	05:45 Чингис Хаан ОУНБ дээр цуглах 07:45 УБ – Сөүл нислэг 12:05 Инчон ОУНБ дээр өдөр бууна. 13:05 Нисэх буудлаас буудал руугаа хөдлөнө 15:30 Буудалдаа байрлаж, амарна 16:00 – 18:00 ХӨГЖЛИЙН НУУЦААС СУРАЛЦЬЯ тусгай сургалт / зөвлөлдөх уулзалт (<i>Буудлын хурлын их танхимд / Сертификат олгоно</i>) Оройн хоол: Буудлын ойролцоо солонгос хоол	Бизнес зочид буудалд 2-оор байрлана.	Орой: Солонгос Хоол
11-р сарын 5 (Лхагва)	Сөүл хот	07:00 Буудалдаа өглөөний цайгаа ууна. 08:00 Арга хэмжээ болох Walker Hill 3Б руу аяллын автобусаараа хөдөлнө. 08:40 GLOBAL HR FORUM 2025 арга хэмжээ (Эхний өдөр) Арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаа болон үндсэн арга хэмжээндээ бие даан оролцоно. 17:00 Буудал руугаа хөдөлнө. 18:00 Оройн хоол 19:00 LOTTE World Tower SEOUL SKY OBSERVATION DESK (123 давхар) 20:00 Буудалдаа очоод амарна	Бизнес зочид буудалд 2-оор байрлана.	Өглөө: Буудалдаа Өдөр: Солонгос хоол Орой: Солонгос хоол
11-р сарын 6 (Пүрэв)	Сөүл хот	07:00 Буудалдаа өглөөний цайгаа ууна. 08:00 Арга хэмжээ болох Walker Hill 3Б руу аяллын автобусаараа хөдөлнө. 09:00 GLOBAL HR FORUM 2025 арга хэмжээ (Сүүлийн өдөр) Үдээс хойш: ХАН МӨРНИЙ CRUISE аялал (E Land Cruise) 19:00 Оройн хоолны дараа буудалдаа очоод амарна	Бизнес зочид буудалд 2-оор байрлана.	Өглөө: Буудалдаа Өдөр: Солонгос хоол Орой: Солонгос хоол
11-р сарын 7 (Баасан)	Сөүл - Үлсан	08:00 Буудалдаа өглөөний цай Буудлаа хүлээлгэж өгнө. 09:00 Кимпо ОУ-н нисэх буудлаас Үлсан хот руу хөдөлнө 12:00-13:00 Korea Airports Corporation Танилцах хөтөлбөр 13:30-14:30 Дотоодын нислэгээр Үлсан хот руу ниснэ. 15:00 Аяллын автобусандаа суугаад Юнескод бүртгэлтэй Бангүчон цэцэрлэгт хүрээлэнгийн музей 16:00 Бангүчон цэцэрлэгт хүрээлэнд аялна 17:00 Үлсан хотын шинэ нэрийн хуудас болсон Trevier шар айрагны Үйлдвэрийн дэргэдэх TRE VILLAGE -д оройн зоог / Networking 20:00 Буудалдаа очоод амарна	Бизнес зочид буудалд 2-оор байрлана.	Буудалдаа өглөөний цайгаа ууна. Өдрийн хоол: Кимпо ОУНБ дээр Оройн хоол: Trevier шар айрагны үйлдвэрийн дэргэдэх TRE VILLAGE -д оройн зоог
11-р сарын 8 (Бямба)	Бүсан - Үлсан	09:00 Буудалдаа өглөөний цайгаа уугаад аялалдаа гарна. 10:30 Бүсаны Хэүндэ далайн эргийн алдарт BLUE LINE галт тэргээр аялна. 12:00 Өдрийн хоол 13:30 Бүсаны Хэүндэ далайн эргийн наран шарлагын газар 15:00 Нэгдсэн Үндсэн Байгууллагын дурсгалын цэцэрлэгт хүрээлэн 16:30 Бүсаны Сунгду далай дээрх CABLE CAR (Busan Air Cruise) -р аялна. 18:00 Оройн хоол 19:30 Буудалдаа очоод амарна.	Бизнес зочид буудалд 2-оор байрлана.	Өглөө: Буудалдаа Өдөр: Солонгос хоол Орой: Солонгос хоол
11-р сарын 9 (Ням)	Бүсан - УБ	08:30 Буудалдаа өглөөний цайгаа уугаад check out хийж аялалдаа гарна. Дэванам цэцэрлэгт хүрээлэн [Далай дээрх дүүжин гүүр] 18:00 Үлсан хотын нисэх буудлаас Кимпо ОУ-н нисэх буудал руу хөдөлнө 23:55 Инчон ОУНБ-аас нутаг буцна. 02:40 УБ Хотод буугаад аялал дуусна.		Өглөө: Буудалдаа
<u>Бидний онцлог:</u>	- Форумын синхрон орчуулга хийх албан ёсны эрхтэй цорын ганц байгууллага 2018 оноос хойш 8 дахь жилдээ Монгол Улсаас оролцох төлөөлөгчдийн зохион байгуулалтыг хийж байна. - БНСУ-н төрийн өмчит байгууллагууд болон итгэмжлэгдсэн аялал жуулчлалын компанитай хамтран ажилладаг. - БНСУ-н Мэргэжлийн институт болон холбоотой хамтран нэмэлт тусгай сургалт (сертификатай) - БНСУ-н тэргүүлэгч компаниудын үйл ажиллагаатай танилцах туршлага судлах хөтөлбөр хэрэгжүүлдэг - Төлөөлөгчдийн цагийг хэмнэх зорилгоор Korea Airports Corporation -н дэмжлэгтэй дотоодын тусгай нислэг үйлддэг. - МХНИ-н гишүүн болон дэмжигч байгууллагууддаа хөнгөлөлт санал болгодог - Арга хэмжээний дараа нийт оролцогчдын хүрээнд EVENT Review зохион байгуулна.			
Жич: Сөүл хотод аяллын үзвэрийн төлбөр [Lotte tower болон cruise аялал]-ийг хасуулж тооцуулах боломжтой: 150,000 ₮				
Утас : 9000-1075, 8000-1075 Жич: Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хөтөлбөрийн цагт өөрчлөлт орж болно.				

Global HR Forum 2025

Global HR Forum нь 2006 оноос эхлэн БНСУ-ын Боловсролын яам, Солонгосын эдийн засгийн өдөр тутмын сонин, Боловсрол, хүний нөөцийн хөгжлийн хүрээлэн (KRIVET) хамтран зохион байгуулж ирсэн олон улсын нэр хүндтэй арга хэмжээ бөгөөд боловсрол, бизнес, төр, иргэний нийгмийн салбаруудын хамтын ажиллагааг дэмжиж, ирээдүйн хөдөлмөрийн зах зээлд тулгарч буй сорилт, боломжийг хэлэлцэх зорилготой. Өнгөрсөн жилүүдэд:

- “Дээд шилжилтийн эринд шаардлагатай авьяас” (2022),
- “AI ба Big Blur-ийн эрин дэх авьяас хөгжлийн хувьсал” (2023),
- “AX and Human” (2024) зэрэг сэдвийг авч хэлэлцэн, дэлхийн нэр хүндтэй эрдэмтэн, судлаачид, бизнесийн удирдагчдыг илтгэгчээр оролцуулсан байдаг.

2024 оны форумд жишээлбэл Geoffrey Hinton, Carly Fiorina зэрэг салбарын нэрт төлөөлөгчид оролцож, олон чиглэлийн хэлэлцүүлэг болон залуу үеийнхэнд зориулсан тусгай сессүүд зохион байгуулагдсан. Харин 2025 оны форум 11 дүгээр сарын 5–6-нд Сөүл хотын Grand Walkerhill зочид буудалд болох бөгөөд энэ жилийн гол сэдэв нь “Symbiotic Intelligence” буюу “**Нэгдмэл оюуны эрин үе**” / “**Хүн ба хиймэл оюуны хамтралын эрин**” байх юм.

Энэхүү сэдэв нь хүн ба хиймэл оюун ухааны харилцааг дан ганц технологийн хүрээнд бус, харин хоёр талын сул болон давуу талыг харилцан нөхөх замаар илүү ухаалаг шийдвэр, бүтээлч гарцыг бий болгох шинэ загвар хэмээн тодорхойлж байна. Хиймэл оюун ухаан нь өргөн хэмжээний мэдээллийг хурдтай боловсруулж, нарийн тоон шинжилгээ хийх чадвартай бол хүн нь ёс зүй, сэтгэл хөдлөл, бүтээлч сэтгэлгээ, нийгмийн харилцааны нарийн мэдрэмжээр илүү давамгайл байр суурь эзэлдэг. Иймээс хүний нөөцийн бодлого, стратеги нь зөвхөн ажилтны сургалт, хөгжлийг дэмжихээс гадна байгууллага бүхэлдээ “хүн ба AI хамтран ажиллах экосистем”-ийг хэрхэн бүрдүүлэхэд чиглэгдэх шаардлагатай болж байна.

2025 оны форумд Siemens компанийн ТУЗ-ийн дарга Jim Hagemann Snabe, Humane Intelligence-ийн захирал Rumman Chowdhury, CMU-ийн роботикийн профессор О Хе-жин зэрэг олон улсын нэр хүндтэй илтгэгчид уригдан оролцож, хүний нөөцийн бодлого, аж үйлдвэрийн хөгжил, нийгмийн өөрчлөлтийн уялдаа холбоог өргөн хүрээнд авч хэлэлцэнэ.

Иймээс Global HR Forum 2025 нь зөвхөн хүний нөөцийн салбарын мэргэжилтнүүдэд төдийгүй **БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГУУД, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ШИЙДВЭР ГАРГАГЧДАД ЗАЙЛШГҮЙ АЧ ХОЛБОГДОЛТОЙ АРГА ХЭМЖЭЭ** болж байна. Учир нь “Symbiotic Intelligence”-ийн эрин үед байгууллагын өрсөлдөх чадварыг зөвхөн хүний нөөцийн менежерүүд бус, удирдлагын түвшний бүх шийдвэр гаргагчид хамтран тодорхойлох шаардлага урган гарч байна.

Товчхондоо, Global HR Forum 2025 нь өмнөх жилийн “AI шилжилт ба хүн” сэдвээс улам бүр гүнзгийрч, хүн ба хиймэл оюун ухааны хам орших харилцааг байгууллагын бодлого, стратегийн төвд авчирснаараа онцлог болж байна.



MD hotel



Hotel Daoom



Дотоодын нислэг [Сөүлээс Үлсан хотруу дотоодын нислэгээр 50 мин ниснэ.]
Солонгост аяллыг гүйцэтгэж буй UMIT ХК нь БНСУ-ын төрийн өмчит Нисэхийн Корпорацийн итгэмжлэгдсэн компани бөгөөд, дотоод нислэгийн дэмжлэг болон, АЧААНЫ ХЯЗГААРЛАЛТГҮЙ, түргэн шуурхай бүртгэл явуулах тусгай үйлчилгээ авах боломжтой.



ТУРШЛАГА СУДЛАХ ХӨТӨЛБӨР: **Korea Airports Corporation**

Солонгосын нисэхийн корпораци нь 1980 онд байгуулагдсан бөгөөд БНСУ-ын төрийн өмчит байгууллага юм. Энэхүү байгууллага нь Сөүл хотын Кансо дүүргийн Гимпо олон улсын нисэх буудлын дэргэд төвтэй. Өнөөдөр нийт 14 олон улсын болон дотоодын нисэх онгоцны буудлыг удирдан ажиллуулдаг. Үүнд Гимпо, Жэжү, Гимхаэ, Дэгү, Чхёнжү, Янгян зэрэг томоохон буудлууд багтдаг. Байгууллагын гол зорилго нь нисэх буудлын барилга, менежмент, үйл ажиллагаа болон агаарын навигацийн тогтолцоог хангах явдал юм. Мөн Иргэний нисэхийн сургалтын төвөөр дамжуулан мэргэжлийн боловсон хүчнийг сурган бэлтгэдэг. Үнэт зүйл нь аюулгүй байдал, тасралтгүй үйлчилгээ, сорилтод бэлэн байдал, итгэлцэл дээр тулгуурладаг. Нийгмийн хариуцлагын хүрээнд сайн дурын үйлчилгээний бүлгээр дамжуулан олон нийтэд чиглэсэн төсөл хэрэгжүүлдэг. 2017 онд тэдний борлуулалтын орлого 8 их наяд 8,831 тэрбум воныг давсан бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 2,264 ажилтантай байна. Тус байгууллага нь зөвхөн нисэх буудлуудын үйл ажиллагааг удирдах төдийгүй нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж буй байгууллага юм.



СӨҮЛ: ЛОТТЕ ВОРЛД ТАУЭР | SEOUL SKY OBSERVATION DESK (123 давхар Солонгосын хамгийн өндөр барилга)



Сөүл хотын Сонпа дүүрэгт байрлах Лотте Ворлд Тауэр нь 123 давхар, 555 м өндөртэй тэнгэр баганадсан Солонгосын хамгийн өндөр барилга юм. 123 давхарт “Сөүл Скай (Seoul Sky)” нэртэй хамгийн өндрөөс Сөүл хотыг тольдон харах боломжтой талбай бий. Дэлхийн хамгийн өндөр цамхагуудын нэг бөгөөд Хан гол болон Сөүл хотын бүх үзэмжийг нэг дороос харах, шалан хэсэг нь шилэн хийцтэй Sky Deck-тай тул эгч доошоо хотыг харах ч боломжтой. Кафе, бэлэг дурсгалын дэлгүүр, тусгай лоунж зэрэг үйлчилгээнүүдтэй.

Үзвэрийн төлбөр: Том хүн 83,700₮ [Аяллын төлбөрт багтсан]

СӨҮЛ | Хан голын эрэг дээрх E LAND CRUISE

1986 оноос хойш Хан мөрөн дээр үйл ажиллагаа явуулж буй алдартай аяллын усан онгоц юм. Үндсэн зогсоол нь Сөүл хотын Ёйодуд байрладаг бөгөөд өдрийн болон шөнийн аяллын олон төрлийн маршруттай. Өдрийн аяллаар та Хан мөрний эрэг дагуу хотын үзэмжийг тайван уур амьсгалтайгаар сонирхох боломжтой. Харин шөнийн аялал дээр Сөүл хотын гэрэлтсэн тэнгэр багана, гүүр, мөн Банпо гүүрийн усан оргилуурыг үзэж болдог. Мөн хөгжимтэй, амьд тоглолт бүхий романтик аялал зохион байгуулдаг.

Төлбөр: Том хүн 59,400 ₮ [Аяллын төлбөрт багтсан]



ҮЛСАН ХОТ: Бангүдэ ДЭЛХИЙН ӨВИЙН МУЗЕЙ



Бангүдэ хадны сүг зураг нь Үлсан хотын Үлжү дүүргийн Дэгогчон голын хажууд байрлах хадан дээр сийлэгдсэн бөгөөд 1995 онд БНСУ-ын Үндэсний хосгүй үнэт өвд №285 дугаарт бүртгэгдсэн, 2023 онд ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгэгдсэн дурсгалт газар юм. Ойролцоогоор 7,000–3,000 жилийн өмнөх шинэ чулуун зэвсгийн үеэс хүрэл зэвсгийн үед хамаарах бөгөөд халим, буга, бар, загас зэрэг 300 орчим дүрсийг агуулдаг. Ялангуяа халимны ан хийж байгааг харуулсан сүг зураг нь дэлхийд ховор бөгөөд далай тэнгисийн соёл судлахад үнэтэй эх сурвалж болдог. Бангүдэ хадны сүг зураг нь эртний хүмүүсийн амьдрал, шүтлэг, урлагийг илтгэх үнэт өв юм.

ҮЛСАН ХОТ: “Тревиер” шар айрагны үйлдвэр, ресторан



“Тревиер” шар айрагны үйлдвэр, ресторан нь Үлсан хотын Үлжү дүүрэгт байрлах бөгөөд Солонгосын крафт шар айргийн анхдагч юм. Энэ газарт шар айрагны үйлдвэр, зөрөг цэцгийн талбай, сургалтын танхим болон хоол, ундаагаар үйлчилдэг ресторан багтдаг. Улаан тоосгон дээвэртэй Европ хэв маягийн барилга нь гэр бүл, найз нөхөд, хосуудад тохиромжтой уур амьсгалыг бүрдүүлдэг. Мөн төрөл бүрийн шар айраг, германы хаксен, шарсан тахиа зэрэг хоолыг амталж болно. Дашрамд дурдахад Бямба гариг бүр үйлдвэрийн аялал хийдэг.



БУСАН ХОТ: BLUE LINE Хэүндэ Блюлайн Парк



Хэүндэ Блюлайн Паркын далайн эргийн галт тэрэг нь Бусан хотын Хэүндэ далайн эргийг даган аялахад зориулсан үзэсгэлэнт аяллын галт тэрэг юм. Мипо өртөө—Чонгсапо—Сончонг өртөө хүртэлх нийт 4.8 км замыг ойролцоогоор 30 минутанд туулж, далайн үзэмжийг тасралтгүй харах боломжтой. Байгальд ээлтэй цахилгаан батарейгаар ажилладаг бөгөөд том цонхтой тул зорчигчид далайн салхи, үзэсгэлэнт байгалтайгаа илүү ойрхон мэдрэмж ав

БУСАН ХОТ: НҮБ-ын дурсгалын цэцэрлэгт хүрээлэн



НҮБ-ын дурсгалын цэцэрлэгт хүрээлэн нь Пусан хотын Намгү дүүрэгт байрлах бөгөөд дэлхий дээрх цорын ганц НҮБ-ын цэргийн дурсгалын газар юм. Солонгосын дайнд (1950–1953) амь үрэгдсэн НҮБ-ын орнуудын цэргүүдийг хүндэтгэн байгуулсан бөгөөд 11 орны 2,300 гаруй дайчдад зориулан байгуулжээ. Ойролцоогоор 13 га талбай бүхий цэцэрлэгт хүрээлэнд дурсгалын цогцолбор, хөшөө, усан сан, алхах замууд байрладаг. Дэлхийн энх тайван, эрх чөлөөний төлөө амь насаа зориулсан цэргүүдийн дурсгалыг мөнхжүүлсэн энэхүү газар нь олон улсын хэмжээнд бэлгэдэлт утга учиртай. 2023 онд ЮНЕСКО-ийн соёлын өвд бүртгэсэн.

БҮСАН ХОТ: Далай дээрх Сонгду BUSAN AIR CRUISE



Бүсн Сонгду далайн cable car (Busan Air Cruise) нь далайн эргээс эхлэлтэй далай дээгүүр дайран өнгөрдөг алдартай аялал жуулчлалын үзмэр юм.

“Сонгду Бэйс” өртөөнөөс баруун зүгт Амнам цэцэрлэгт хүрээлэн буюу “Сонгду Скайпарк” хүртэл 1.62 км замыг туулдаг. Далай дээгүүр дунджаар 86 метрийн өндөрт зорчих ба зорчигчид Бүсн хотын үзэмж, далайн гайхамшгийг дээрээс тольдон харах боломжтой. 2017 онд шинэчлэгдэн дахин ашиглалтад орсон энэхүү дүүжин тэрэг нь өнөөдөр гэр бүл, хосууд, жуулчдын заавал зорьж очих газрын нэг болжээ.



ҮЛСАН ХОТ: Дэванам далайн эргийн цэцэрлэгт хүрээлэн

Үлсаны зүүн хэсэгт орших Дэванам цэцэрлэгт хүрээлэнгээр аялахад далайн эрэг дагуу байрласан өвөрмөц хад чулуутай үзэсгэлэнт байгаль таныг угтана. Паркийн хамгийн сонирхолтой хэсэг бол далай дээгүүр татсан **дүүжин гүүр** юм. Жуулчид энд нар мандах үзэсгэлэнт мөчийг харахын тулд өглөө эрт очих нь элбэг.



СӨҮЛ | ХӨГЖЛИЙН НУУЦААС СУРАЛЦЪЯ | Тусгай сургалт & зөвлөлдөх уулзалт

